



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 142

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2.1, 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 12 нэрийн, нийт 21,112,565.03 (хорин нэгэн сая нэг зуун арван хоёр мянга таван зуун жаран таван төгрөг гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил” төслийн нэгжийн зохицуулагч Ж.Түвшинсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны 05 дугаар сарын 11 -ны/ний өдрийн  
 00000000000000000000 дугаар тогтоолын хавсралт

"ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН ТӨСЛИЙН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ" ТӨСЛИЙН ҮНДСЭН  
 ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТЛАЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
	<b>Компьютер, техник хэрэгсэл</b>				
1	Зөөврийн компьютер	2009.11.01	2	1,685,600.00	3,371,200.00
2	Ширээний компьютер	2009.11.01	7	1,126,900.00	7,888,300.00
3	Тог баригч	2009.11.01	8	216,000.00	1,728,000.00
4	Дүрс буулгагч (Сканнер)	2009.11.01	1	199,000.00	199,000.00
5	Зургийн аппарат	2009.11.01	1	669,800.00	669,800.00
6	Ширээний компьютер	2010.04.08	2	1,500,420.74	3,000,841.48
7	Тог баригч	2010.04.08	2	249,842.58	499,685.16
8	Хэвлэгч (Принтер)	2010.04.08	1	989,813.50	989,813.50
9	Хэвлэгч (Принтер)	2009.11.01	1	599,900.00	599,900.00
10	Дүрс бичлэгийн видео камер	2010.04.08	1	1,650,599.34	1,650,599.34
	<b>Тоног төхөөрөмж</b>				
11	Усны аппарат	2009.10.28	1	383,636.00	383,636.00
12	Суурин утас	2009.11.11	3	43,929.85	131,789.55
			<b>30</b>		<b>21,112,565.03</b>
	<b>Нийт дүн</b>		<b>Хорин нэгэн сая нэг зуун арван хоёр мянга таван зуун жаран таван төгрөг гурван мөнгө</b>		